



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 46

Улаанбаатар хот

Түр журам батлах тухай


Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27¹ дугаар зүйлийн 27¹.1.1, 27¹.1.4, Коронавируст халдварт (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хот болон орон нутаг хооронд иргэдийн зорчих хөдөлгөөнийг зохицуулах түр журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг ханганд, зохион байгуулалтын арга хэмжээ авч, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд /Л.Халтар/, аймаг, нийслэл, сум, дүүргийн Онцгой комиссын дарга наарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар /Т.Гантулга/, Онцгой байдлын ерөнхий газар /хошууч генерал Г.Ариунбуян/, Цагдаагийн ерөнхий газар /цагдаагийн хурандадаа Ж.Болд/-т тус тус даалгасугай.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Улсын онцгой комиссын даргын “Түр журам батлах тухай” 2021 оны 42 дугаар тушаалыг 2021 оны 5 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.



Улсын онцгой комиссын даргын 2021 оны
46. дугаар тушаалын хавсралт

**ХОТ БОЛОН ОРОН НУТАГ ХООРОНД ИРГЭДИЙН ЗОРЧИХ
ХӨДӨЛГӨӨНИЙГ ЗОХИЦУУЛАХ ТҮР ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хот болон орон нутаг хоорондын зорчигч тээвэр /авто, төмөр зам болон агаарын тээвэр/, жолооч, зорчигчийн зорчих үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмыг мөрдлөг болгоно.

1.2. Энэхүү түр журам нь тээврийн хэрэгслээр зорчигч (Монгол Улс болон гадаад улсын бүх насны хүн), жолооч, тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, тэдгээрт хяналт тавьж буй төрийн байгууллагад хамаарна.

1.3. Энэхүү түр журмаар зохицуулаагүй бусад харилцааг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

Хоёр. Зорчигч тээврийн зохион байгуулалт

2.1. Хот болон орон нутаг хооронд зорчих зорчигчоос дараах бичиг баримтыг шалган, халдвараас сэргийлэх дэглэмийг мөрдүүлж нэвтрүүлнэ:

2.1.1. коронавируст халдварт (Ковид-19)-ын /цаашид “коронавируст халдварт“ гэх/ эсрэг вакцинжуулалтын бүрэн тун авсанаас хойш 14 хоногийн хугацаа өнгөрсөн нотлох баримт;

2.1.2. сүүлийн 4 сарын хугацаанд коронавируст халдвараар өвчилж эдгэрсэн эрүүл мэндийн байгууллагын магадлагаа;

2.1.3. коронавируст халдварын тохиолдол бүртгэгдээгүй орон нутаг (аймаг, сум)-аас зорчих хөдөлгөөн эхэлсэн болон энэхүү журмын 2.1.1, 2.1.2-т заасан баримт бичигтэй зорчигчоос бусад тохиолдолд коронавируст халдварын бх-ПГУ шинжилгээний сөрөг хариу /шинжилгээ өгсөн өдрөөс 3 хоногийн хугацаанд хүчинтэй/, эсхүл антигенд суурилсан түргэвчилсэн шинжилгээний сөрөг хариу /шинжилгээ өгсөн өдрөөс 2 хоногийн хугацаанд хүчинтэй/;

2.1.4. иргэний үнэмлэх болон хувийн мэдээллийг нотлох бусад бичиг баримт;

2.2. 0-17 насны хүүхдээс коронавируст халдварын бх-ПГУ болон антигенд суурилсан түргэвчилсэн шинжилгээний сөрөг хариу шаардахгүй бөгөөд шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдэд асуумж авч, биеийн халууныг үзэж, коронавируст халдварын эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн тохиолдолд хүүхдээс заавал түргэвчилсэн шинжилгээ авч, холбогдох хариу арга хэмжээг тухайн орон нутгийн онцгой комисс хариуцан зохион байгуулна.

2.3. Сүүлийн 4 сарын хугацаанд коронавируст халдвараар өвчилж эдгэрсэн, вакцинжуулалтын бүрэн тунд хамрагдсанаас хойш 14 хоногийн хугацаа өнгөрсөн зорчигчоос төрийн байгууллага, улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, аж ахуйн нэгж, авто тээврийн шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдэд бх-ПГУ болон түргэвчилсэн шинжилгээний сөрөг хариу шаардахгүй.

2.4. Коронавируст халдварын тохиолдол бүртгэгдээгүй орон нутаг (аймаг, сум)-аас зорчих хөдөлгөөн эхэлсэн зорчигчоос эрүүл мэндийн асуумж авч, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэн нэвтрүүлнэ.

2.5. Энэхүү журмын 2.1.1, 2.1.2, 2.4-т заасан нотлох баримттай зорчигчийг гэрийн ажиглалтад шилжүүлэхгүй бөгөөд тухайн зорчигч тээврийн хэрэгслээр зорчих болон бусад үед халдвараас сэргийлэх дэглэмийг чанд сахина.

2.6. Улсын хэмжээнд гамшигаас хамгаалах бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед иргэдийн хот, орон нутаг хооронд зорчих хөдөлгөөний чиглэлд зөвхөн Улсын онцгой комиссоос хязгаарлалт тогтоож, тогтоосон хүрээнд аймаг, нийслэл, сум, дүүргийн Онцгой комисс зохион байгуулалтын арга хэмжээ авна.

2.7. Энэхүү журмын 2.1-т заасан бичиг баримтыг шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдэд цахим болон цаасан хэлбэрээр шалгах бөгөөд зорчигч нь дээрх бичиг баримтыг биедээ заавал авч явна.

Гурав. Тээврийн хэрэгслээр зорчигчид тавигдах шаардлага, хүлээх үүрэг

3.1. Коронавируст халдварын тохиолдол илэрсэн орон нутгаас хот болон бусад орон нутаг хооронд зорчихдоо энэхүү журамын 2.1-т заасан бичиг баримтыг биедээ авч явах бөгөөд замын шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдэд тухай бүр шалгуулна.

3.2. Зорчигч тээврийн хэрэгслээр зорчихын өмнө нэг удаагийн амны хаалт, бээлий, гар халдвартгуйжүүлэгч, хувийн хэрэгцээний эд зүйлс, замд хэрэглэх хоол, хүнс болон хогийн уутыг урьдчилан бэлтгэсэн байна.

3.3. Зорчигч тээвэрлэлтийн туршид халдвараас сэргийлэх дэглэмийг мөрдөж, (хооллооос бусад нөхцөлд нэг удаагийн амны хаалтыг авахгүй байх 2 цаг тутам эсхүл бохирдсон тухай бүр амны хаалтыг солих, гараа бохирдох бүрт халдвартгуйжүүлэх, бусадтай биеэр хүрэлцэхгүй байх, ойролцоо суудалд зорчиж буй бусад хүнтэй харьцах үедээ амны хаалт хэрэглэж, хүн хоорондын зайд барих), эрх бүхий ажилтан, албан хаагчдын тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлнэ.

3.4. Зорчигч өөрийн бэлтгэсэн хогийн уутанд хог хаягдлаа хийн битүүмжилж хог хаягдлыг цуглуулах цэгт төвлөрүүлнэ.

3.5. Тээврийн хэрэгсэл дотор болон гадагш нус, цэр, шүлс, хог хаягдлыг ил задгай хаях, утсаар чанга удаан ярихыг хориглоно.

3.6. Халдварын сэжигтэй шинж тэмдэг илэрвэл өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндийг эрсдэлд оруулахаас сэргийлж, энэ талаар тээвэрлэлтийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажилтанд нэн даруй мэдэгдэнэ.

Дөрөв. Тээврийн байгууллагад тавигдах шаардлага

4.1. Хот болон орон нутаг хоорондын зорчигч тээврийн хэрэгслийн тасалбарыг цахимаар худалдаалах нөхцөлийг бүрдүүлж, цахимаар худалдаалах боломжгүй тохиолдолд халдвараас сэргийлэх дэглэмийг мөрдөж, үйлчилгээ үзүүлнэ.

4.2. Тээвэрлэгч нь нэг удаагийн амны хаалт, бээлий, гар халдвартгуйжүүлэгчийг урьдчилан бэлтгэж, зорчигчдыг худалдан авах нөхцөлөөр хангана.

4.3. Энэхүү түр журмын 2.1-т заасан баримт бичгийг хянан шалгаж, тээврийн хэрэгсэлд нэвтрүүлнэ.

4.4.Агаарын хөлөг, зорчигчийн вагон, автобусаар зорчих зорчигчдоос хүн хоорондын зай барьж зорчих, амны хаалт зүүх, халдвараас сэргийлэх дэглэм мөрдөж үйлчлүүлэхийг шаардаж, заавар, зөвлөмжөөр хангана.

4.5.Хот хоорондын автобусаар 40 зорчигчоос илүү хүн тээвэрлэхгүй байх.

4.6.Биеийн халуун 37.1 хэмээс дээш болон коронавируст халдварын бусад шинж тэмдэг илэрсэн зорчигчийг тээвэрлэхгүй ба холбогдох эрүүл мэндийн байгууллагад хандахыг зөвлөнө.

4.7.Зорчигчийг тасалбарт бичигдсэн суудалд суух, суудал солихгүй, зайлшгүйгээс бусад тохиолдолд суудлаас босохгүй байх, амны хаалтыг тогтмол зүүх, бусад зорчигчтой харьцахгүй байх зэргийг зорчигчид анхааруулж, хяналт тавина.

4.8.Өөрийн байгууллагын ажилтан, албан хаагч, жолоочийг коронавируст халдварын эсрэг вакцинжуулалтын бүрэн тунд хамруулах ажлыг зохион байгуулна.

4.9.Тээврийн хэрэгслийг зорчигч тээвэрлэхээс өмнө болон тээвэрлэж дууссаны энгийн угаалгын бодисоор угааж цэвэрлэсэн байна.

4.10. Авто тээврийн үйлчилгээний байгууллага дараах шаардлага

4.10.1.Эрх бүхий байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр зорчигч тээврийн үйлчилгээний цагийн хуваарьт зохицуулалт хийнэ;

4.10.2.тээврийн багийн бүрэлдэхүүнд энэхүү түр журам болон онцгой нөхцөл байдлын үед авч хэрэгжүүлэх заавар, зөвлөмжийг танилцуулж, сургасан байна;

4.10.3.тээврийн багийг нэг удаагийн амны хаалт, анхны тусламж, цэвэрлэгээний цомог, гар халдвартгүйжүүлэгч, хогийн уут зэргээр хангана;

4.10.4.автобусны эхний эгнээг чөлөөлж, ээлжийн жолоочийн амрах хэсгийг гаргах бөгөөд жолооч нарыг тусгаарлах хаалтаар зорчигчдоос тусгаарлана;

4.10.5.тээврийн хэрэгсэлд хөшигнөөс бусад суудлын бүрээс, гоёлын эд зүйл зэрэг халдварын эрсдэлтэй хэрэгсэл ашиглахгүй байх, гадаргууг халдвартгүйжүүлэх бодисыг байрлуулж, зорчигч бүр гадаргуугийн халдвартгүйжүүлэлт хийх нөхцөлийг бүрдүүлнэ;

4.10.6.удаан хугацаагаар тээвэрлэлтийн үйлчилгээ үзүүлэх бол тухай бүр тээврийн хэрэгслийг угааж цэвэрлэн, хавартгүйжүүлэлт хийж, зорчигчдод халдвараас сэргийлэх дэглэмийг сахиулна.

4.10.7.тээвэрлэгч нь зорчигчийг бүрэн буулгасны дараа тээврийн хэрэгсэлд эцсийн халдвартгүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагын зөвлөмжийг дагуу хийнэ.

4.11.Төмөр замын тээвэрлэгч байгууллага дараах шаардлага

4.11.1.нийт ажилтнуудад энэхүү түр журам болон бусад холбогдох заавар, чиглэл, халдвараас сэргийлэх дэглэмийн талаар зааварчилгаа өгч хэрэгжилтэд хяналт тавина;

4.11.2.нийт ажилтнуудыг нэг удаагийн амны хаалт, анхны тусламжийн болон цэвэрлэгээний цомог, гар халдвартгүйжүүлэгч, зайнаас халуун хэмжигч, хогийн уут зэргээр хангана;

4.11.3.зорчигчийн вагонуудад анхны тусламжийн болон цэвэрлэгээний цомог, гар халдвартгүйжүүлэгч, зайнаас халуун хэмжигч, хогийн уутыг байрлуулсан байна;

4.11.4.зорчигч суухаас өмнө вагон бүрийг угааж цэвэрлэнэ;

4.11.5.зорчигчийн вагоны цонхны хөшигнөөс бусад гудас, бүтээлэг, ор хөнжлийн даавуу зэрэг халдвартын эрсдэлтэй эд зүйлс аль болох ашиглахгүй байх;

4.11.6.галт тэргэнд ажилтан болон зорчигч хувийн ариун цэврийг хэрхэн сахих, халдвараас сэргийлэх талаарх зөвлөмжийг байрлуулж, мэдээллээр хангасан байна;

4.11.7.галт тэрэгний ариун цэврийн өрөөнд гар угаах шингэн саван, цаасан алчуур, гар халдвартайжүүлэгч болон хог хаягдлыг цуглуулах утыг хүрэлцэхүйц хэмжээгээр байрлуулна.

4.11.8.халдвартын сэжигтэй тохиолдол илэрвэл галт тэрэгний дарга нь диспетчерээр дамжуулан тухайн орон нутгийн Онцгой комиссын Шуурхай штабт мэдэгдсэний дагуу бэлэн байдлыг хангудлаа;

4.11.9.галт тэрэгний ажилтан зорчигчийн зорчих тасалбар болон энэхүү журмын 2.1-т заасан бичиг баримтыг шалгаж, суулгана;

4.11.10.галт тэргэнд халдвартайжүүлэлтийг мэргэжлийн байгууллагаар эсхүл мэргэжлийн байгууллагын зөвлөмжийн дагуу хийнэ;

4.11.11.галт тэргэнд ажил үүрэг гүйцэтгэх ажилтнуудыг коронавируст халдвартын эсрэг вакцинжуулалтын бүрэн тунд хамруулсан байна;

4.11.12.галт тэргээр зорчикж буй иргэдээс эрүүл мэндийн асуумж авч, холбогдох мэргэжлийн байгууллагад мэдээлэл хүргүүлнэ;

4.11.13.тээвэрлэлтийн үргэлжлэх хугацааны турш зорчигчдод хоол хүнсний зүйлсээр үйлчилгээ үзүүлэхгүй байх, уух зүйлээр үйлчлэх бол нэг удаагийн хэрэглээний аяга ашиглан тавиур дээр байрлуулан өгнө. Гараас гарч өгөхийг хориглоно. Үйлчилгээ үзүүлсний дараа тавиурыг халдвартайжүүлнэ.

4.12.Агаарын тээвэрлэгч байгууллага дараах шаардлагыг хангана:

4.12.1.нислэгийн чиглэл, маршрут, цагийн хуваарийг урьдчилан батлуулж нислэгийн зөвшөөрөл авна;

4.12.2.нисэх бүрэлдэхүүн, техник үйлчилгээний болон газрын үйлчилгээний ажилтнуудад үйл ажиллагаанд мөрдөх холбогдох заавар журмыг танилцуулж, аймаг, нийслэлийн онцгой комиссын шуурхай штабын утасны дугаарыг бэлтгэж өгнө;

4.12.3.нисэх бүрэлдэхүүн болон газрын үйлчилгээний ажилтнуудад халдварт хамгааллын иж бүрэн хувцас, нүүрний хаалт, нэг удаагийн амны хаалт, бээлий, гар халдвартайжүүлэгч, цэвэрлэгээний бодис, хог хийх уут зэргээр хангана;

4.12.4.нислэгийн турш ариун цэврийн өрөөнд гар угаах шингэн саван, цаасан алчуур, гар халдвартайжүүлэгч болон хог хаягдлыг цуглуулах утыг шаардлагатай цэгүүдэд хүрэлцэхүйц хэмжээгээр байрлуулна;

4.12.5.зорчигчийн суудал бүрд нислэгийн үед баримтлах халдвараас сэргийлэх дэглэмийн тухай санамж, анхааруулга байрлуулна;

4.12.6.зорчигчийн амны хаалтыг 2 цаг тутамд, бохирдсон тохиолдол (найталгасан, ханиалгасан гэх мэт)-д солиулах ба хэрэглэсэн амны хаалтыг суудлын урд байрлах цаасан уутанд хийж, шар өнгийн хогийн уутанд цуглуулна;

4.12.7.нислэгийн явцад агаарын хөлгийн дарга, нисгэгч бүхээгийн хаалтыг нээхгүй, шаардлагатай тохиолдолд агаарын хөлгийн үйлчлэгчтэй дотуур холбоогоор холбогдоно;

4.12.8.нислэгийн үргэлжлэх хугацааны турш зорчигчдод хоол хүнсний зүйлсээр үйлчилгээ үзүүлэхгүй. Зайлшгүй шаардлагаар уух зүйлээр үйлчлэх бол нэг удаагийн хэрэглээний аяга ашиглан тавиур дээр байрлуулан өгнө. Гараас гарч өгөхийг хориглоно. Үйлчилгээ үзүүлсний дараа тавиурыг халдвартгуйжүүлнэ;

4.12.9.халдвартын сэжигтэй тохиолдол илэрвэл агаарын хөлгийн дарга нь нисэн очих нисэх буудлын Нислэгийн хөдөлгөөний ажилтнаар дамжуулан тухайн орон нутгийн Онцгой комиссын шуурхай штабт мэдэгдсэний дагуу агаарын хөлгийг нисэх буудалд буухаас өмнө бэлэн байдлыг хангулна;

4.12.10.агаарын хөлгийн зорчигчийн бүхээгийн хүрэлцэх гадаргуу, ариун цэврийн өрөөнд нислэг үйлдэхээс өмнө болон нислэгийн дараа халдвартгуйжүүлэлт хийж, хог хаягдлыг цуглуулан амыг сайтар битүүмжилж, зориулалтын цэгт төвлөрүүлнэ.

4.13.Авто болон төмөр зам, нисэх буудлууд дараах шаардлагыг хангана:

4.13.1.ирэх, явах зорчигч, орох гарах хөдөлгөөнийг нэг чиглэлийн урсалаар давхцуулахгүй байхаар зохисн байгуулна;

4.13.2.бүртгэлийн цэг, хүлээлгийн танхимд зорчигч, иргэдийн бөөгнөрөл үүсгэхгүй, хүн хоорондын зайл бариулж, тэмдэг тэмдэглэгээг байршуулсан байна;

4.13.3.үйлчилгээний ажилтнуудыг нэг удаагийн амны хаалт, /нүүрний хамгаалах халхавч/ бээлий хэрэглэж иргэдэд үйлчилж хэвшүүлэх, халдвараас сэргийлэх дэглээнийг чанд сахиулна;

4.13.4.халдвартын сэжигтэй зорчигч илэрсэн үед холбогдох байгууллагад мэдэгдэж эрүүл мэндийн шуурхай хариу арга хэмжээний багт шилжүүлэх хүртэл бусад зорчигчоос түр тусгаарлаж, ойрын хавьтлыг тогтоосон байна;

4.13.5.коронавируст халдвараас сэргийлэх, эрсдэлийг бууруулах, халдвараас сэргийлэх дэглээнийг сахиулах чиглэлээр мэдээ, мэдээлэл, сээрэмжлүүлэг, ухуулах хуудас зэргийг бэлтгэн нийтийн эзэмшлийн талбай, нийтийн тээвэр, олон нийтийн үйлчилгээний газраар зорчих иргэдэд түгээж, байрлуулан, зарлан мэдээллийн давтамжийг нэмэгдүүлнэ;

4.13.6.захиргаа, үйлчилгээний ажилтнуудад үйл ажиллагаанд мөрдөх холбогдох заавар журмыг танилцуулж, аймаг, нийслэлийн Онцгой комиссын шуурхай штабын утасны дугаарыг бэлтгэж өгсөн байна;

4.13.7.үйлчилгээний заал танхimuудад мэргэжлийн байгууллагын зөвлөмжийн дагуу халдвартгуйжүүлэлт хийнэ;

4.13.8.хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулан, тухай бүр зайлуулна.

Тав. Хувийн болон албаны тээврийн хэрэгслийн зорчигчид тавигдах шаардлага, хүлээх үүрэг

5.1.Зорчих явцад хэрэглэсэн амны хаалт, ахуйн хог хаягдлыг тухайн тээврийн хэрэгслийн жолооч цуглуулж, хог хаягдлыг цуглуулах цэгт битүүмжлэн хаяна.

5.2.Коронавируст халдвартын тохиолдол илрээгүй бүс, нутгаас зорчиж буй иргэн эрүүл мэндийн асуумжийг үнэн зөв бөглөж, халдвараас сэргийлэх дэглээнийг мөрднө.

5.3.Халдвартын сэжигтэй шинж тэмдэг илэрвэл өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндийг эрсдэлд оруулахаас сэргийлж, тухайн зорчиж буй нутаг дэвсгэр дэх хамгийн ойр эрүүл мэндийн байгууллагад нэн даруй хандана.

Зургаа. Аймаг, нийслэлийн Онцгой комиссын үүрэг

6.1.Онцгой комиссын Шуурхай штабаас зорчигч тээвэрлэлтийн хөдөлгөөний мэдээллийг нэгтгэн боловсруулж, Улсын Онцгой комиссыг мэдээллээр хангах.

6.2.Гамшигаас хамгаалах бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээг зохицуулахтай холбоотой хэрэгжүүлж буй хариу арга хэмжээний журам, заавар, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуйж, хяналт тавина.

6.3.Коронавируст халдвартын шинж тэмдэг бүхий зорчигчийн талаарх мэдээлэл ирвэл холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд заасны дагуу хариу арга хэмжээг нэн даруй авна.

6.4.Коронавируст халдвартын тохиолдол илэрсэн бүс, нутгаас өөрийн оршин суух газар руу зорчиж буй эсхүл удаан хугацаагаар байрлах иргэдийн гэрийн тусгаарлан ажиглалтад хяналт тавих ажлыг зохион байгуулна.

Долоо. Тээврийн хэрэгслийн шалган нэвтрүүлэх товчоо, цэгүүдийн үүрэг

7.1.Энэхүү журмын 2.1, 2.4-т заасан бичиг баримтыг үндэслэн тээврийн хэрэгсэл, зорчигчдыг саадгүй нэвтрүүлнэ.

7.2.Тээврийн хэрэгсэл болон зорчигчдын халдвараас сэргийлэлтийн дэглэмд хяналт тавих, зөрчлийг тухай бүр арилгуулна.

7.3.Тээврийн хэрэгслээр зорчигчдыг энэхүү журмын 2.1-т заасан баримт бичгийн зөрчилтэй тохиолдолд тухайн тээврийн хэрэгсэл, зорчигчийг нэвтрүүлэхгүй.

Найм. Бусад

8.1.Түр журмыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан тогтоол, шийдвэр, заавар, дүрэм, журамд нийцсэн байна.

8.2.Энэхүү түр журмыг зөрчсөн иргэн, албан тушаалтан, хуулийн этгээдэд “Гамшигаас хамгаалах тухай” хууль, “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуульд заасныг үндэслэн үндэслэн Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Иргэний тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.